



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 5 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар  
хот

Улаанбаатар хотын Олон улсын нисэх  
онгоцны шинэ буудлын талаар авах  
зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 5 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох 49 хувийг эзэмших “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулсугай.

2. “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит компанийг хууль тогтоомжийн дагуу байгуулж, дүрмийг батлахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай.

3. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох хувь, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг томилсугай.


4. “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2018 оны үйл ажиллагааны зардлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн нарт тус тус даалгасугай.

5. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын барилга байгууламж, эд хөрөнгийг төрийн өмчид бүртгэн авч, Иргэний нисэхийн ерөнхий газрын балансад бүртгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай.

6. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 322 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн “2017 оны 12 дугаар” гэснийг “2018 оны 6 дугаар” гэж, мөн тогтоолын 5 дугаар зүйлийн “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-ын бэлэн байдлыг хангаж, үйл ажиллагааг нь эхлүүлэхэд шаардагдах” гэснийг “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох хувьд

хөрөнгө оруулах болон нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах” гэж тус тус өөрчилсүгэй.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан ““Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 322 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам, тээврийн хөгжлийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Ж.БАТ-ЭРДЭНЭ